



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны стратеги,
бүтцийн хөтөлбөр, ажлын байрны
тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/323 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны Стратеги, бүтцийн хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, ажилтнуудын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
20 13 оны 04 дугаар сарын 19 -ний өдрийн 14
дугаар тушаалын 1-р хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
СТРАТЕГИ, БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Оршил

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр /цаашид “стратеги, бүтцийн хөтөлбөр” гэж нэрлэнэ/ нь Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм батлах тухай Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захирамжийг үндэслэн тус газрын үйл ажиллагаа, эрхлэх ажлын хүрээг тодорхойлоход чиглэгдэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн хөтөлбөрийн үндсэн зорилго нь нийслэл Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засгийн болон нийгэм соёлын үр нөлөөг нь дээшлүүлэхтэй холбогдсон бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх оновчтой бүтэц, зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг тогтоох, алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэх стратегийн зорилтуудыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Үйл ажиллагааны стратеги, бүтцийн хөтөлбөр нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 3-р сарын 25-ны өдрийн А/323 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн боловсруулав.

1.3. Хариуцлага, тайлагналын тогтолцоо

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, түүний Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн удирдлага дор үйл ажиллагаа явуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.4. Хууль тогтоомжийн орчин

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь дор дурьдсан хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

Монгол Улсын Үндсэн хууль
Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
Төрийн албаны тухай хууль

Төсвийн тухай хууль
 Аялал жуулчлалын тухай хууль
 Байгаль орчныг хамгаалах тухай хууль
 Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль
 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
 Бусад хууль тогтоомж

1.5. Үйл ажиллагааны хэрэгцээний эх үүсвэр

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн хүрээ нь дараах байдалтай байна.



1.6. Үйл ажиллагааны төрөл

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь газрын даргаар дамжуулан зохих журмын дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын орлогч, Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хурал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд мэдээлэл, шийдвэрийн төсөл оруулах бөгөөд эдгээр асуудлыг мэргэшлийн өндөр түвшинд боловсруулж дэмжлэг үзүүлнэ.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын ажилтнууд нь байгууллагын хөгжлийн стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт уялдуулан стратегийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах үндсэн үйл ажиллагаа явуулж дор дурдсан хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ.

А. Үйлчилгээ:

Чиг үүргийн дагуу төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх
Гадаад дотоодын жуулчид, аж ахуйн нэгжүүдийг судалгаа, мэдээллээр хангах
Хууль, тогтоомж, журмын биелэлтийг хангах
Салбарын хөгжлийн эрэлт хэрэгцээг харгалзан төрөл бүрийн сургалт, зөвлөгөөн,
уулзалт, арга хэмжээг зохион байгуулах
Иргэд, байгууллагын санал хүсэлтийг судалж шийдвэрлэх, хариу өгөх

Б. Зөвлөгөө:

Хууль, дүрэм, журмыг боловсронгуй болгох санал боловсруулах
Дээд байгууллагын шийдвэрийн төсөл боловсруулах болон шийдвэр
боловсруулалтыг сайжруулах
Төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилтийг сайжруулах

В. Зохицуулалт

Газрын үйл ажиллагааг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудын
үйл ажиллагаатай уялдуулан холбох
Газрын эрхэм зорилго, гол зорилт, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний
биелэлтийг хангах талаар зохицуулалт хийх
Дээд байгууллагын бодлого, үйл ажиллагааг сурталчилах, салбарын байгууллагуудын
хүсэлт, саналыг дээд байгууллагад хүргэх, төр хувийн хэвшлийн байгууллагуудын
дунд ажил хэрэгч холбоо тогтоох

2. НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ЗОРИЛТУУД

2.1. Алсын хараа

Аялал жуулчлалыг нийслэл хотын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд
шийдвэрлэх үүрэг бүхий салбар болгон хөгжүүлнэ.

2.2. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он гэхэд жилдээ 5 сая гадаадын жуулчин
хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хот
болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

2.3. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Нийслэлийн Аялал жуулчлалын газар дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй
ажиллана. Үүнд:


- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох
- Жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, зорих газрын менежментийн бодлого, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх

- Жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх
- Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах
- Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

3.1. Үйл ажиллагааны стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн тухай мэдээлэл гэсэн газрын үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлж ажиллана.

Газрын үйл ажиллагааны тогтолцоо



3.2 Үйл ажиллагааны стратегийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор захиргааны албан тушаалд тавигдах шаардлага, албан тушаал /ажлын байр/-ны тодорхойлолтод тохирох иргэнийг шилж сонгож холбогдох албан тушаалд зохих журмын дагуу томилон ажиллуулах үйл ажиллагааг цаг тухайд нь гүйцэтгэнэ.

3.3 Төрийн албан хаагч бүртэй албан тушаалын зорилго, үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Үйл ажиллагааны төлөвлөгөө” /үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ/-г харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулан ажиллах бөгөөд уг төлөвлөгөө /гэрээ/-ний биелэлтийг үндэслэн тэдгээрийн үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг тогтоосон хугацаанд нь үнэлж дүгнэнэ.


3.4. Төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтанд хамруулах зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, албан тушаал бууруулах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

3.5. Ажилтны боловсрол, мэргэжлийн бэлтгэл туршлага, ур чадвар, хувь хүний болон багаар ажиллахын давуу талыг зөв зохистой хослуулах, ажлын цагийг үр бүтээлтэй


ашиглах зэрэг нь үйл ажиллагааны стратегийн зорилтоо үр дүнтэй хэрэгжүүлэх нөөц гэж үзэж тэдгээр нөөцийг дээд зэргээр дайчлахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна.

3.6. Үйл ажиллагаандаа төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэглэнэ.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын бүтцийн схем



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2013 оны 04 дугаар сарын 19-ний өдрийн 14
дугаар тушаалын 2-р хавсралт



АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар		
2. Ажлын байрны нэр: Төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	2.1 Албан тушаалын ангилал: Дэс түшмэл	2.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-6
3. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга	3.1 Албан тушаалын ангилал: Эрхэлсэн түшмэл	3.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-10
4. Ажлын байрны шууд харъяалан удирдах албан тушаал: -	4.1 Албан тушаалын нэр: -	4.2 Албан тушаал эрхлэгчдийн тоо: -

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	Аялал жуулчлалын талаар төрөөс болон нийслэлээс баримталж буй бодлого чиглэлтэй уялдуулан Улаанбаатар хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж, биелэлтийг тайлагнах	
2. Ажлын байрны үндсэн зорилт	2.1 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1. Нийслэлд аялал жуулчлалыг хөгжүүлэх дунд, богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг тайлагнах 2. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах 3. Нийслэлийн аялал жуулчлалын зөвлөлийн ажлыг хариуцан зохион байгуулах	1. Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлоготой нийцсэн, байгаль орчин, нийгэм соёл, эдийн засагт сөрөг нөлөөгүй аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг хөгжүүлэх зорилттой уялдсан байна. 2. Тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хэрэгжилт явцыг журмын дагуу тайлагнасан байна.	
3. Ажлын байрны гол үйл ажиллагаа	3.1 Хугацаа, хуваарь	
1. Ажлын байрны 1-р үндсэн зорилтын хүрээнд: А. Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, Нийслэлийн аялал жуулчлалын хөтөлбөрийн биелэлт гаргах Б. Яам, нийслэлээс боловсруулж байгаа хөтөлбөр, төсөлд санал өгөх, аялал жуулчлалтай холбогдол бүхий НЗД-ын захирамж,		30%

шийдвэрийн төсөл, танилцуулгыг боловсруулах В. Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хурал, иргэдийн төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлэх асуудлыг хариуцан зохион байгуулж бэлтгэлийг хангах	
2. Ажлын байрны 2-р үндсэн зорилтын хүрээнд: А. Газрын улирал, хагас жил, жилийн ажлыг аялал жуулчлалын эрэлт хэрэгцээнд тулгуурлан төлөвлөх, сарын ажлын тайланг нэгтгэж хүргүүлэх Б. Газрын даргын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гаргах, дараа жилийн гэрээний төслийг боловсруулах В. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагад танилцуулах, ажлын явц, үр дүн, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, иргэдийн саналыг газрын үйл ажиллагаа, бодлого, төлөвлөгөөнд тусгах	50%
3. Ажлын байрны 3-р үндсэн зорилтын хүрээнд А. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, ажлын уялдааг хангах Б. Нийслэлийн аялал жуулчлалын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, хурлыг зохион байгуулах	10%
4. Ажлын байрны бусад зорилтын хүрээнд А. Хууль, тогтоол, захирамж, журам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дотоод ажил үүргийн хуваарийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах Б. Байгууллагын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэр, хугацаатай өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллах В. Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг чанд баримтлах, хариуцсан ажлын чиглэлээрх бичиг баримтыг стандартын дагуу архивын бүрдүүлэлт хийж, архивын ажилтанд хүлээлгэн өгөх	10%

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Аялал жуулчлалын чиглэлээр өндөр хөгжилтэй оронд суралцаж төгссөн байх	Аялал жуулчлалын чиглэлээр бакалавраас дээш зэрэгтэй суралцаж төгссөн байх
		Мэргэжил	Аялал жуулчлалын удирдлага	Бизнесийн удирдлага
		Мэргэшил	Аялал жуулчлалын төслийн удирдлага, менежмент	Төслийн удирдлага, менежмент


		Туршлага	Төрийн албанд 3-аас дээш жил ажилласан байх	Аялал жуулчлалын салбарт 10-с доошгүй жил ажилласан байх
		Ур чадвар	-Удирдан зохион байгуулах ур чадвартай -Харьцааны соёл, багаар ажиллах чадвартай -Албан хэрэг хөтлөх, албан бичиг боловсруулах чадвартай -Компьютерийн хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн - Монгол хэл, бичгийг бүрэн эзэмшсэн	-
	1.2 Тусгай шаардлага		- Англи хэлийг бүрэн эзэмшсэн	

Г. ХҮЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект		
1.1 Байгууллагын дотор		1.2 Байгууллагын гадна талд байгаа
1. Газрын дарга 2. Ахлах мэргэжилтнүүд 3. Бусад ажилтнууд		1. Харъяа яам 2. НИТХ-ын ажлын алба 3. НЗД, салбар хариуцсан орлогч 4. НЗДТГ 5. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд 6. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны тодорхойлолтоор тогтоосон үүргийг газрын даргын өмнө бүрэн хариуцаж, ажлын шаардлагыг өндөр түвшинд биелүүлнэ. МУ-ын хууль тогтоомж, төрийн албаны тангараг, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрдөнө.	
3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл	3.1 Санхүүгийн	Цалин хөлс ТЗ-6 гэсэн зэрэглэлээр тогтоосон албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн нэмэгдлээс бүрдэнэ
	3.2 Биет хөрөнгийн	- Албан өрөөний тавилга - Компьютер, холбооны болон бусад техник хэрэгсэл - Бичгийн хэрэгсэл
	3.3 Хүний	1
	3.4 Бусад	-

4. Ажлын байрны нөхцөл	4.1 Ердийн нөхцөл	Ажлын хэвийн орчин, нөхцөлд ажиллана
	4.2 Онцгой нөхцөл	-

Д. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан
Албан тушаалын нэр: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Г.БАЯСГАЛАН /гарын үсэг/ /Эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ 2013 оны 04 дугаар сарын 19-ны өдөр	Албан тушаалын нэр: ДАРГА  Лэмдэг/..... Э.БАТТУЛГА /гарын үсэг/ /Эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ 2013 оны 04 дугаар сарын 19-ны өдөр

АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар		
2. Ажлын байрны нэр: Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан ахлах мэргэжилтэн	2.1 Албан тушаалын ангилал: Дэс түшмэл	2.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-6
3. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга	3.1 Албан тушаалын ангилал: Эрхэлсэн түшмэл	3.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-10
4. Ажлын байрны шууд харъяалан удирдах албан тушаал: -	4.1 Албан тушаалын нэр: -	4.2 Албан тушаал эрхлэгчдийн тоо: -

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээг сайжруулах, холбогдох стандарт, дүрэм журмыг боловсронгуй болгох	
2. Ажлын байрны үндсэн зорилт	2.1 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1. Үйлчилгээний стандарт, дүрэм, журмыг боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх, сурталчлах 2. Жуулчдад зориулсан шинэ үйлчилгээ нэвтрүүлэхэд иргэд, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх 3. Нийслэлд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд тогтвортой үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	1. Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний чанар, түвшин дээшилсэн байна. 2. Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний чанар, түвшин дээшилсэн байна. 3. Стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоо, тэдний ашиг орлого, ажиллах хүчний тоо нэмэгдсэн байна.	
3. Ажлын байрны гол үйл ажиллагаа	3.1 Хугацаа, хуваарь	
1. Ажлын байрны 1-р үндсэн зорилтын хүрээнд: А. Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журмыг нийслэлд хэрэгжүүлэх Б. Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах В. аялал жуулчлал өндөр хөгжсөн орнуудын стандарт, зөвлөмж, бусад норм нормативийг судалж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах		30%
2. Ажлын байрны 2-р үндсэн зорилтын хүрээнд: А. Стандарт, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээ		30%

бүхий аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгжийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах Б. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төрөл бүрийн ажлуудыг зохион байгуулах 3. Ажлын байрны 3-р үндсэн зорилтын хүрээнд А. Үйлчилгээний байгууллагуудад чанарын зэрэглэл тогтоох, зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах Б. Аялал жуулчлал, үйлчилгээний салбарын шинэ техник технологиудыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах В. Аялал жуулчлал, үйлчилгээний байгууллагуудыг дэмжих эрх зүйн орчин бий боловсронгуй болгох, аялал жуулчлалын салбарын хуулийг дагаж гарах дүрэм, журам, эрхийн актуудыг боловсруулах 4. Ажлын байрны бусад зорилтын хүрээнд А. Хууль, тогтоол, захирамж, журам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дотоод ажил үүргийн хуваарийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах Б. Байгууллагын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэр, хугацаатай өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллах В. Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг чанд баримтлах, хариуцсан ажлын чиглэлээрх бичиг баримтыг стандартын дагуу архивын бүрдүүлэлт хийж, архивын ажилтанд хүлээлгэн өгөх	30% 10%
--	-----------------------

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Аялал жуулчлалын чиглэлээр бакалавраас дээш зэрэгтэй суралцаж төгссөн байх	Өндөр хөгжилтэй оронд аялал жуулчлалын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн байх
		Мэргэжил	Аялал жуулчлалын удирдлага	Бизнесийн удирдлага
		Мэргэшил	Аялал жуулчлалын менежмент	Зочлох үйлчилгээний менежмент
		Туршлага	Төрийн албанд 3-аас дээш жил ажилласан байх	Аялал жуулчлалын салбарт 10-с доошгүй жил ажилласан байх

		Ур чадвар	- Удирдан зохион байгуулах ур чадвартай - Харьцааны соёл, багаар ажиллах чадвартай - Албан хэрэг хөтлөх, албан бичиг боловсруулах чадвартай - Монгол хэл, бичгийг бүрэн эзэмшсэн	-
		2.1 Тусгай шаардлага	- Ёс зүйн хэм хэмжээг чанд сахих	

Г. ХҮЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект		
1.1 Байгууллагын дотор	1.2 Байгууллагын гадна талд байгаа	
1. Газрын дарга 2. Ахлах мэргэжилтнүүд 3. Бусад ажилтнууд	1. Харьяа яам 2. НИТХ-ын ажлын алба 3. НЗД, түүний орлогч 4. НЗДТГ-ын хэлтэс, ажилтнууд 5. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд 6. ТББ 7. Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад аж ахуй нэгж байгууллагууд, иргэд	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны тодорхойлолтоор тогтоосон үүргийг газрын даргын өмнө бүрэн хариуцаж, ажлын шаардлагыг өндөр түвшинд биелүүлнэ. МУ-ын хууль тогтоомж, төрийн албаны тангараг, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрдөнө.	
3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл	3.1 Санхүүгийн	Цалин хөлс ТЗ-6 гэсэн зэрэглэлээр тогтоосон албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн нэмэгдлээс бүрдэнэ
	3.2 Биет хөрөнгийн	- Албан өрөөний тавилга - Компьютер, холбооны болон бусад техник хэрэгсэл - Бичгийн хэрэгсэл
	3.3 Хүний	1
	3.4 Бусад	-
4. Ажлын байрны нөхцөл	4.1 Ердийн нөхцөл	Ажлын хэвийн орчин, нөхцөлд ажиллана
	4.2 Онцгой нөхцөл	-

Д. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан
--	--

Албан тушаалын нэр:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

..... Г.БАЯСГАЛАН
/гарын үсэг/ /Эцэг, эхийн
нэрний эхний үсэг, өөрийн нэр/

20¹³ оны ⁰⁴ дугаар сарын ¹⁹ -ны өдөр

Албан тушаалын нэр:
ДАРГА

Гэмдэг/

..... Э.БАТТУЛГА
/гарын үсэг/ /Эцэг, эхийн нэрний
эхний үсэг, өөрийн нэр/

20¹³ оны ⁰⁴ дугаар сарын ¹⁹ -ны өдөр

АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А.ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар		
2. Ажлын байрны нэр: Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	2.1 Албан тушаалын ангилал: Дэс түшмэл	2.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-5
3. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга	3.1 Албан тушаалын ангилал: Эрхэлсэн түшмэл	3.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-10
4. Ажлын байрны шууд харъяалан удирдах албан тушаал: -	4.1 Албан тушаалын нэр: -	4.2 Албан тушаал эрхлэгчдийн тоо: -

Б.ЧИГ ҮҮРЭГ

1.Ажлын байрны зорилго	Байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, сонгох, үр дүнтэй ажиллуулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх, удирдах дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй тогтмол, ил тод байлгах, газрын дарга, ажилтнуудыг цаг үеийн мэдээллээр хангаж, байгууллага, ажилтны ажлын үр дүнг дээшлүүлэх	
2.Ажлын байрны үндсэн зорилт	2.1 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1. Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон хууль тогтоомж эрх зүйн баримт бичгийг мөрдөж, газрын даргын тушаал, өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг хангуулах, биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж, тайлагнах, мэдээллэх 2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудал, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлүүлэх, зохион байгуулах 3. Ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх хөгжүүлэх урт, богино хугацааны сургалтын хөтөлбөр гарган, сургалт зохион байгуулах, гадаад, дотоодын мэргэшүүлэх сургалтанд хамруулах	1. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй явагдсан байна. 2. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдаж, тогтвор суурьшилтай ажиллах үр дүнтэй ажиллах нөхцөл бүрдсэн байна. 3. Байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх чадварлаг мэргэшсэн боловсон хүчин бүрдсэн байна.	

3. Ажлын байрны гол үйл ажиллагаа	3.1 Хугацаа, хуваарь
Ажлын байрны 1-р үндсэн зорилтын хүрээнд А. Газрын дарга, ажилтнуудад дээд байгууллагын шийдвэр, захирамжийг цаг хугацаанд нь тогтмол танилцуулах, гарын авлага, мэдээ материалаар хангах Б. Удирдах дээд шатны байгууллагуудаас ирсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг улирал, жилээр гарган үр дүнг хангахад чиглэсэн санал дүгнэлт боловсруулах В. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөлгөөнөөс өгсөн үүрэг даалгаварыг танилцуулах, биелэлтийг хангуулж ажиллах, тайлан мэдээг хүргүүлэх Г. Байгууллагын хурал шуурхай зөвлөлгөөний тэмдэглэл хөтөлж, ажилтнуудад өгсөн үүрэг даалгаварын карт хөтлөх, биелэлтийг мэдээллэх Д. Цаг үеийн ажилтай холбоотой ажлын хэсэг, комисс ажиллуулах тушаалыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг мэдээлэх Е. Ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт тусгах, хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээ өгөх Ё. Ажилтнуудын хувийн хэрэгт баяжилт хийх, шинээр орсон ажилтанд хувийн хэрэг нээх Ж. Төрийн албан хаагчийн хөдөлгөөний тайланг гаргаж тайлан мэдээг хүргүүлэх, нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлтэй хамтарч ажиллах З. Ажилтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг авах, бүртгэх, мэдээллэх, хадгалах, нууцлах, тайлагнах И. Ажилтнуудын ажлын цагийн ашиглалтын мэдээг гаргах, мэдээлэх Й. Ажилтнуудын улирал, жилийн ажлын тайланг хүлээн авах, үр дүн, гүйцэтгэлийг мэдээллэх К. Байгууллагын хэмжээнд байгуулсан гэрээг бүртгэх, хадгалах, биелэлтийг хангуулах Л. Мэргэжилтэн, төрийн албан хаагч, ажилтнуудын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээг байгуулах, ажлын үр дүнд үнэлгээ өгөх санал гаргах 2. Ажлын байрны 2-р үндсэн зорилтын хүрээнд А. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх Б. Ажилтнуудад сарын бүрийн цалинг хугацаанд нь олгуулах, ээлжийн амралтын хуваарь гарган батлуулж, хуваарийн дагуу биеэр эдлүүлэх ажлыг зохион байгуулах В. Ажилтнууд болон тэдний гэр бүлд шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах Г. Ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл баталгааг хангуулах Д. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, баяр ёслолын арга хэмжээнд оролцуулах Е. Ажлын байрны нөхцөл, техник тоног төхөөрөмж, бичиг хэрэгслийн хангамжийг хариуцах	60% 20%

3. Ажлын байрны 3-р үндсэн зорилтын хүрээнд А. Ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх урт, богино хугацааны сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр гарган холбогдох байгууллагатай гэрээ байгуулан сургалтыг зохион байгуулах Б. Цаг үеийн сургалт, мэдээлэл, ажил мэргэжлийн уулзалт зохион байгуулах, ижил төстэй байгууллагын туршлагыг судлах, үзүүлэх сургалт, семинар зохион байгуулах	10%
4. Ажлын байрны бусад зорилтын хүрээнд А. Хууль, тогтоол, захирамж, журам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дотоод ажил үүргийн хуваарийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах Б. Байгууллагын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэр, хугацаатай өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллах В. Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг чанд баримтлах, хариуцсан ажлын чиглэлээрх бичиг баримтыг стандартын дагуу архивын бүрдүүлэлт хийж, архивын ажилтанд хүлээлгэн өгөх	10%

В.ТАВИГДАХ ШААРДЛАГА


1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлсэн байх
		Мэргэжил	Хүний нөөцийн менежер	-
		Мэргэшил	Төрийн удирдлагын менежер	-
		Туршлага	Төрийн албанд 10-аас дээш жил ажилласан байх	Аялал жуулчлалын салбарт 3-с доошгүй жил ажилласан байх
		Ур чадвар	- Удирдан зохион байгуулах ур чадвартай - Харьцааны соёл, багаар ажиллах чадвартай - Албан хэрэг хөтлөх, албан бичиг боловсруулах чадвартай - Монгол хэл, бичгийг бүрэн эзэмшсэн	-

	2.2 Тусгай шаардлага	- Ёс зүйн хэм хэмжээг чанд сахих	
--	-----------------------------	----------------------------------	--

Г.ХҮЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект			
1.1 Байгууллагын дотор талд байгаа		1.2 Байгууллагын гадна талд байгаа	
1. Газрын дарга 2. Ахлах мэргэжилтнүүд 3. Бусад ажилтнууд		1. Харъяа яам 2. НИТХ-ын ажлын алба 3. НЗД болон түүний орлогч 4. НЗДТГ-ын хэлтэс, ажилтнууд 5. Бусад байгууллага болон иргэд	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага		Ажлын байрны тодорхойлолтоор тогтоосон үүргийг газрын даргын өмнө бүрэн хариуцаж, ажлын шаардлагыг өндөр түвшинд биелүүлнэ. МУ-ын хууль тогтоомж, төрийн албаны тангараг, байгууллагын дотоод журмыг дагаж мөрдөнө	
3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл	3.1 Санхүүгийн	Цалин хөлс ТЗ-5 гэсэн зэрэглэлээр тогтоосон албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн нэмэгдлээс бүрдэнэ	
	3.2 Биет хөрөнгийн	- Албан өрөөний тавилга - Компьютер, холбооны болон бусад техник хэрэгсэл - Бичгийн хэрэгсэл	
	3.3 Хүний	1	
	3.4 Бусад	-	
4. Ажлын байрны нөхцөл	4.1 Ердийн нөхцөл	Ажлын хэвийн орчин, нөхцөл байдалд ажиллана	
	4.2 Онцгой нөхцөл	-	

Д.БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч		Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан	
Албан тушаалын нэр: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН		Албан тушаалын нэр: ДАРГА	
 /гарын үсэг/ Г.БАЯСГАЛАН /Эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/		 /Тэмдэг/ /гарын үсэг/ Э.БАТТУЛГА /Эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/	
2013 оны 04 дугаар сарын 19 -ны өдөр		2013 оны 04 дугаар сарын 19 -ны өдөр	

АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар		
2. Ажлын байрны нэр: Архив, бичиг хэргийн эрхлэгч	2.1 Албан тушаалын ангилал: Төрийн үйлчилгээ	2.2 Албан тушаалын зэрэглэл: ТҮ-5
3. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга	3.1 Албан тушаалын ангилал: Эрхэлсэн түшмэл	3.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-10
4. Ажлын байрны шууд харъяалан удирдах албан тушаал: -	4.1 Албан тушаалын нэр: -	4.2 Албан тушаал эрхлэгчдийн тоо: -

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	Монгол Улсын Архивын тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль, баримт бичгийн стандарт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын үндсэн заавар холбогдох бусад эрх зүйн акт зааврыг байгууллагын хэмжээнд мөрдүүлж, хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, цахим архив, мэдээлийн технологийг нэвтрүүлнэ.	
2. Ажлын байрны үндсэн зорилт	2.1 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зааврын дагуу хөтлөн явуулах 2. Байгууллагын архивын үйл ажиллагааг зааврын дагуу хөтлөн явуулах 3. Даргад тусалж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлийг хангах 4. Бусад	1. Байгууллагын баримт бичиг зохион бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх, ангилан төрөлжүүлэх, албан хэрэгт хадгалах, мэдээлэл лавлагаанд ашиглах ажлыг хариуцна. 2. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг боловсронгуй болгох, орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлэх 3. Даргад тусалж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлийг хангах	
3. Ажлын байрны гол үйл ажиллагаа	3.1 Хугацаа, хуваарь	
1. Ажлын байрны 1-р үндсэн зорилтын хүрээнд: А. Байгууллагад ирсэн баримт бичгийг хүлээн авах, ангилах, бүртгэх, удирдлагад танилцуулах, холбогдох ажилтанд шилжүүлэх, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих Б. Явуулсан бичгийг бүртгэх, хариутай бичгийн шийдвэрлэлтэд		40%

хяналт тавьж ажиллах

В. Байгууллагад ирсэн өргөдөл гомдлыг бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах

Г. Баримт бичгийг шилжүүлсэн, хянасан, боловсруулсан тэмдгийг хэрэглэх, ирсэн бичиг болон өргөдөл гомдолд бүртгэл хяналтын карт хөтлөх

Д. Байгууллагад ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг мөн шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг сар, улирал, хагас бүтэн жилээр ажилтан бүр дээр гаргаж тайлагнаж ажиллах, удирдлагыг мэдээллээр хангах

Е. Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гарсан дүрэм, журмын дагуу баримт бичиг зохион бүрдүүлэх, байгууллагын хэмжээнд мөрдүүлж ажиллах

Ё. Байгууллагын ажилтнуудад албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилтийн асуудлаар арга зүйн зөвлөгөө өгч, сургалт явуулах

Ж. Байгууллагын үйл ажиллагаанд үүсч хөтлөгдсөн баримт бичиг, мэдээллийг ангилах, төрөлжүүлэх, мэдээллийн санд оруулах

З. Газрын даргын зөвшөөрсөн албан бичиг, тушаал шийдвэрийг бүртгэж албан бичгийн хэвлэмэл хуудсанд буулгах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

И. Байгууллагын тухайн онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж байгууллагын дэргэдэх ББНШК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулах

Й. Хэвлэмэл хуудасны захиалга, ашиглалт, зарцуулалтыг бүртгэж, хяналт тавьж, зарцуулалтын тайлан мэдээг хагас жил, жилээр гаргаж тайлагнаж ажиллах

40%

2. Ажлын байрны 2-р үндсэн зорилтын хүрээнд:

А. Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт баримт хүлээж авах хуваарь төлөвлөгөө гаргаж, ажилтнуудаас хугацаанд нь акт бүртгэлээр хүлээн авах.

Б. Ажилтнуудад үүсч хөтлөгдсөн бүх төрлийн баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх. Тухайлбал: Цаасан суурьт болон кино гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэг, цахим, шинжлэх ухаан зураг төслийн баримт.

В. Архивт хадгалагдаж буй задгай баримтыг нягтлан шалгаж, эмхлэн цэгцлэх,

Г. Гэмтэлтэй баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх

Д. Архивын цаасан болон тусгай төрлийн бүх баримтад данс, бүртгэл жагсаалт үйлдэж байгууллагын дэргэдэх ББНШК болон төрийн архивын дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар хэлэлцэж батлуулах

Е. Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцлийг хангаж, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөж ажиллах. Чийгтэй цэвэрлэгээ, цэвэрлэгээ үйлчилгээ, гэрэл дулааны болон чийг дулааны горимыг мөрдлөг болгож ажиллах

Ё. Архивын баримтыг байгууллага иргэдэд ашиглуулах, сурталчлах, нийгэм шинжлэх ухааны зорилгоор болон лавлагаа мэдээлэлд өргөнөөр ашиглуулж, бүртгэл үйлдэж ажиллах. Ашиглуулсан баримтыг хугацаанд нь архивт буцааж авах

Ж. Эрдэм шинжилгээний лавлах буюу "Түүхчилсэн лавлах",

“Танилцуулга” үйлдэх, баяжилт хийх

3. Архивын баримтын хадгалалт хамгаалалт болон тоо бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан алдаа дутагдлыг арилгах зорилгоор иж бүрэн болон хэсэгчилсэн, сэдэвчилсэн тооллогыг удирдамжийн дагуу зохион байгуулах, ажлын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах

20%

И. Тоо бүртгэлийг хөтөлж, хяналт тавьж ажиллах. /Данс, бүртгэл, жагсаалт, устгах хэргийн акт, архивын гэрчилгээ, түүхчилсэн лавлах, архивын баримт ашиглуулсан бүртгэл гэх мэт/

Й. Архивын хэрэг буюу хадгаламжийн нэгж бүрдүүлэх асуудлаар байгууллагын ажилтнуудад арга зүйгээр хангаж ажиллах, ажлын байран дээр болон мэргэжлийн байгууллагатай хамтарч сургалт зохион байгуулах явуулах

К. Байгууллагын дэргэдэх ББНШК-ын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах, хурлын шийдвэрлэлтийг хангуулж, баримтжуулж ажиллах

Л. Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх чиглэлээр санал санаачлагатай ажиллах, архивын баримтын хадгалалт, хамгаалалт эрэлт хайлт, ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах, түргэн шуурхай болгох

М. Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, архивын баримтын талаарх мэдээ тайланг заасан хугацаанд гаргаж, тайлагнах

Н. Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг чанд баримтлах, хариуцсан ажлын чиглэлээр бичиг баримтыг стандартын дагуу архивын бүрдүүлэлт хийж, төрийн архивын ажилтанд хүлээлгэн өгөх

3. Ажлын байрны 3-р зорилтын хүрээнд

А. Даргын өрөөний эмх цэгц, зохион байгуулалтыг хариуцаж ажиллах нөхцөл байдлыг хангах

Б. Зочид төлөөлөгчдийг хүлээн авах, цайны үйлчилгээ үзүүлэх, эелдэг боловсон харьцах, үдэн гаргах

В. Даргын өдөр тутмын ажилд туслах, утсан харилцааны болон байгууллагын хэмжээнд болж буй үйл ажиллагааны талаар шуурхай мэдээллээр хангах

Г. Удирдлагаас өгөгдсөн болон цаг үеийн чанартай ажлын шуурхай зохион байгуулалтыг хангаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллах

Д. Даргын албан ёсны ажил төрөл, уулзалт арга хэмжээг төлөвлөн явуулж цаг үеийн чанартай хурал зөвлөгөөний тэмдэглэл хөтлөх

Е. Байгууллагын хэмжээнд шаардлагатай хэвлэлийн захиалга, шуудангийн хүргэлтийг хийх

Ё. Гадуур ажлаар явагсадын бүртгэлийг хийж удирдлагад мэдээлэх

4. Ажлын байрны бусад зорилтын хүрээнд

А. Хууль, тогтоол, захирамж, журам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дотоод ажил үүргийн хуваарийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах

Б. Байгууллагын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэр, хугацаатай өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллах

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА


1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх	-
		Мэргэжил	Архив, аялал жуулчлалын удирдлага	-
		Мэргэшил	Төрийн удирдлага, архив, албан хэрэг хөтлөлт	-
		Туршлага	Төрийн албанд ажилласан туршлагатай байх	-
		Ур чадвар	- Удирдан зохион байгуулах ур чадвартай - Харьцааны соёл, багаар ажиллах чадвартай - Албан хэрэг хөтлөх, албан бичиг боловсруулах чадвартай - Монгол хэл, бичгийг бүрэн эзэмшсэн	-
	Тусгай шаардлага		- Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих - Ажлын цаг ашиглалт баримтлах - Англи хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх - Байгууллагын болон хувийн нууц хадгалах	-

Г. ХҮЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект			
1.1 Байгууллагын дотор талд байгаа		1.2 Байгууллагын гадна талд байгаа	
1. Газрын дарга 2. Ахлах мэргэжилтнүүд 3. Бусад ажилтнууд		1. Харьяа яам 2. НИТХ-ын ажлын алба 3. НЗД болон түүний орлогч 4. НЗДТГ-ын хэлтэс, ажилтнууд 5. Бусад байгууллага болон иргэд	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага		Ажлын байрны тодорхойлолтоор тогтоосон үүргийг газрын даргын өмнө бүрэн хариуцаж, ажлын шаардлагыг өндөр түвшинд биелүүлнэ. МУ-ын хууль тогтоомж, төрийн албаны тангараг, байгууллагын дотоод журмыг дагаж мөрдөнө	
3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл	3.1 Санхүүгийн	Цалин хөлс ТҮ-5 гэсэн зэрэглэлээр тогтоосон албан тушаалын цалин, ур чадварын болон бусад нэмэгдлээс бүрдэнэ	

	3.2 Биет хөрөнгийн	- Албан өрөөний тавилга - Компьютер, холбооны болон бусад техник хэрэгсэл - Бичгийн хэрэгсэл
	3.3 Хүний	1
	3.4 Бусад	-
4.Ажлын байрны нөхцөл	4.1 Ердийн нөхцөл	Ажлын хэвийн орчин, нөхцөл байдалд ажиллана
	4.2 Онцгой нөхцөл	-

Д. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан
Албан тушаалын нэр: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Г.БАЯСГАЛАН /гарын үсэг/ /Эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ 2013 оны 04 дугаар сарын 19-ны өдөр	Албан тушаалын нэр: ДАРГА  Тэмдэг/ Э.БАТТУЛГА /гарын үсэг/ /Эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ 2013 оны 04 дугаар сарын 19-ны өдөр

АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар		
2. Ажлын байрны нэр: Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	2.1 Албан тушаалын ангилал: Дэс түшмэл	2.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ - 5
3. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга	3.1 Албан тушаалын ангилал: Эрхэлсэн түшмэл	3.2 Албан тушаалын зэрэглэл: ТЗ-10
4. Ажлын байрны шууд харъяалан удирдах албан тушаал: -	4.1 Албан тушаалын нэр: -	4.2 Албан тушаал эрхлэгчдийн тоо: -

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	Хот дотор болон хот орчимд аялах, жуулчлах иргэдийн тоог нэмэгдүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэх	
2. Ажлын байрны үндсэн зорилт	2.1 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
